



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

---

# ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2020 оны II улирал/

---

## ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

/2020 оны II улирал/

Тайланд карт гаргагч, хүлээн авагч 12 банк, карт хүлээн авагч 1 байгууллагын төлбөрийн карт, төхөөрөмж, бусад төлбөрийн хэрэгсэл, Монголбанкаар дамжсан их, бага дүнтэй гүйлгээний мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар нэгтгэж, үзүүлэв. Картын хэрэглээг хот ба орон нутгаар, идэвхтэй болон идэвхгүй ашиглагдаж байгаа гэж ангилахаас гадна картын нэр төрлөөр (Ү карт, Виза, Мастеркарт, ЮнионПэй, Американ Экспресс, ЖейСиБи) тус бүрт нь авч үзэв. Мөн картын үйлчилгээнд ашиглагдаж буй төхөөрөмжийн тоо (ПОС, МПОС, ПОБ, АТМ<sup>1</sup>, CDM<sup>2</sup>, CRM<sup>3</sup>, Цахим худалдаа, Киоск<sup>4</sup>), карт ашиглан хийсэн гүйлгээний тоо, дүнг карт гаргагч, хүлээн авагч банкаар, өөрийн болон бусад клирингийн системд хийгдсэн байдлаар ангилж үзүүллээ.


Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй ба багцын гүйлгээний Автомат клиринг хаус (АСН+) систем болон их дүнтэй гүйлгээний Банксүлжээ системээр дамжсан гүйлгээний тоо, дүнг улирлаар авч үзэн, өөрчлөлт ба нийт гүйлгээнд эзлэх хувь хэмжээг

тодорхойлов. Тайланд дурдагдсан тоон мэдээллийг нэгтгэсэн хүснэгтийг хавсралтаар үзүүлэв.

### 1. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

#### • Картын тоо

Банкуудын гаргасан картын тоо 2020 оны II улирлын байдлаар 3.9 сая ширхэг байгаа нь өмнөх улирлаас 115 мянга буюу 3.1 хувиар, өмнөх оны II улирлын үзүүлэлттэй харьцуулахад 210.2 мянган ширхэгээр буюу 5.8 хувиар тус тус өссөн байна. Нийт картын 46.8 хувь буюу 1.8 сая карт идэвхтэй ашиглагдаж байгааг Зураг 1-г үзүүлэв.



Идэвхтэй ашиглагдаж байгаа картын тоо өмнөх улирлаас 154 мянга буюу 9.3 хувиар, өмнөх оны II улирлын үзүүлэлтээс 210.2 мянга буюу 5.8 хувиар тус тус өссөн байна

<sup>1</sup> АТМ зөвхөн бэлэн мөнгөний зарлага хийнэ

<sup>2</sup> CDM зөвхөн бэлэн мөнгөний орлого хийнэ

<sup>3</sup> CRM бэлэн мөнгөний орлого, зарлага хийнэ

<sup>4</sup> ПОС төхөөрөмжтэй


(Хүснэгт I). Дэлхийн улс орон даяар хурдацтайгаар тархсан “COVID-19” буюу коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс тогтоосон хөл хорио хэсэгчлэн суларч, үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг буцаан нээж байгаатай холбоотойгоор 2020 оны II улиралд нийт идэвхтэй ашиглагдаж буй картын тоо өсчээ.

Картын хэрэглээний тайлан (өссөн дүнгээр сая ширхэг)

| Хүснэгт I                          | 2020 он, I улирал | 2019 он, II улирал | 2020 он, II улирал | Өсөлт/бууралт (2019-II/2020-II) |       |
|------------------------------------|-------------------|--------------------|--------------------|---------------------------------|-------|
|                                    |                   |                    |                    | Тоо                             | Хувь  |
| Картын тоо                         | 3.75              | 3.65               | 3.86               | 0.21                            | 5.76  |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо | 1.65              | 1.51               | 1.81               | 0.30                            | 20.02 |

Картын хэрэглээг аймаг, хотоор авч үзвэл 2020 оны II улирлын байдлаар орон нутагт 1.3 сая ширхэг төлбөрийн карт ашиглагдаж байгаа нь өмнөх улирал буюу 2020 оны I улирлын үзүүлэлтээс 33.6 мянган ширхэг буюу 2.7 хувиар, өмнөх оны II улирлын үзүүлэлтээс 162.9 мянган ширхэг буюу 14.7 хувиар нэмэгдсэн байна. Хотуудын хувьд карт эзэмшигчдийн тоо 2.6 сая ширхэг байгаа нь өмнөх улирлын үзүүлэлтээс 81.5 мянган ширхэг буюу 3.3 хувиар, өмнөх оны II улирлаас 35.2 мянган ширхэг буюу 1.4 хувиар тус тус өссөн байгааг Зураг 2-т үзүүлэв. Өмнөх оны II улирлын 69.7% ба 30.3%-тай харьцуулахад тайлант улирлын байдлаар нийт карт эзэмшигчдийн 67% нь хот, 33% нь хөдөө орон нутгийн иргэд

байгаа нь хөдөө орон нутаг дахь карт эзэмшигч нэмэгдэж байгааг харуулж байна. (Хүснэгт II).



Картын хэрэглээний тайлан

Өссөн дүнгээр


| Хүснэгт II    | 2019 он, II улирал | 2020 он, II улирал | Өсөлт/бууралт (2019-II/2020-II) |       |
|---------------|--------------------|--------------------|---------------------------------|-------|
|               |                    |                    | Тоо                             | Хувь  |
| Хотууд        | 2,554,280          | 2,589,431          | 35,151                          | 1.38  |
| Бусад аймгууд | 1,110,613          | 1,273,483          | 162,870                         | 14.66 |

Банкуудын зүгээс техник технологийн дэвшлийг ашиглаж, үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлснээр санхүүгийн байгууллагын үйлчилгээг карт эзэмшигчид хүргэх боломж нэмэгдэж байгаа нь хөдөө, орон нутагт амьдарч буй иргэдийн картын тоо өсөх шалтгаан болж байна.

Банкууд 6 төрлийн картыг өөрийн банкны оноосон нэрээр гаргаж байгаа ба эдгээрийн тоо хэмжээг төрөл тус бүрээр нь Хүснэгт 1б-д үзүүлэв. Тайлант хугацаанд 2.53 сая




ширхэг буюу нийт картын 65.5 хувийг үндэсний брэнд ₮ карт, 20.2 хувийг ЮнионПэй карт, 11.6 хувийг Виза карт тус тус эзэлж байна. Харин Мастеркарт, Американ Экспресс болон ЖейСиБи картууд хамгийн бага буюу 0.1-ээс 2.4 хувийг эзэлж байгааг Зураг 3-т үзүүлэв. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны II улирлын үзүүлэлттэй харьцуулахад Амекс картын тоо 38 хувиар, ЖейСиБи картын тоо 9.6 хувиар, ₮ картын тоо 7.5 хувиар тус тус буурсан. Тайлант хугацаанд Мастеркарт картын тоо 105.6 хувиар, ЮнионПэй картын тоо 54.7 хувиар, Виза картын тоо 27.4 хувиар өмнөх оны үзүүлэлтээс тус тус нэмэгдсэн байна.



#### • Төхөөрөмжийн тоо

Өмнөх оны II улиралд төхөөрөмжийн тоог 5 нэр төрлөөр ангилж бүртгэдэг байсан бол, 2019 оны IV улирлаас эхлэн шинэ зааврын

дагуу төхөөрөмжийн тоог 4 төрлөөр нэмж, нийт 9 төрлөөр бүртгэдэг болсон. Үүнд ПОС, МПОС, ПОБ, АТМ, СДМ, СРМ, Цахим худалдаа болон Киоск төхөөрөмжүүд багтана. Нийт төхөөрөмжийн 88.4 хувийг ПОС, 3.8 хувийг ПОБ, 2.9 хувийг МПОС, 2.1 хувийг СРМ, 1.5 хувийг АТМ эзэлж байгаа бол бусад төхөөрөмжүүд 0.1-ээс 1 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 4-д үзүүлэв.



Орон даяар хэрэглэгдэж буй нийт төхөөрөмжийн тоог өмнөх улиралтай харьцуулахад 3.9 мянган ширхэг буюу 5.6 хувиар өссөнөөр 72.9 мянган ширхэг болоод байна (Хүснэгт 26). Үүнийг өмнөх оны II улиралтай харьцуулахад 14.4 мянган ширхэг буюу 24.6 хувиар өсчээ.

Төхөөрөмжийн тоог хот, аймаг тус бүрээр харьцуулж үзэхэд улсын хэмжээний нийт


төхөөрөмжийн 23.2 хувь нь хөдөө орон нутагт, 76.8 хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байршиж байгаа нь хүн амын төвлөрөлтэй холбоотойгоор төлбөрийн картын хэрэглээ хотуудад төвлөрсөн хэвээр байгааг харуулж байна (Хүснэгт 2а).

• Гүйлгээний тоо, дүн

Банкууд өөрийн гаргасан картаар өөрийн банкны сүлжээ, ҮЦГТ-ийн нэгдсэн сүлжээ болон гадаад сүлжээнд гүйлгээ хүлээж авч байгаагаас 5.3 их наяд төгрөгийн 80.9 сая ширхэг буюу нийт картын гүйлгээний тооны 64.6 хувийг, нийт дүнгийн 56.5 хувийг үндэсний брэнд ₮ карт эзэлж байгаа бол, ЮнионПэй карт нийт гүйлгээний тоо ба дүнгийн 22.2 хувийг, Виза карт нийт гүйлгээний 12.4 хувь, дүнгийн 20.7 хувийг эзлэж байна. Харин Мастеркарт, Американ экспресс болон ЖейСиБи картууд харьцангуй бага буюу гүйлгээний тооны

0.04-өөс 0.7, дүнгийн 0.04-өөс 0.54 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 5-д үзүүлэв.

Төлбөрийн системийн оролцогчид өөрийн гаргаснаас гадна дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд карт уншигч төхөөрөмжөөр дамжуулан хүлээн авдаг. Тайлант хугацаанд нийт 9.2 их наяд төгрөгийн 118.5 сая ширхэг гүйлгээг амжилттай хүлээн авсан нь өмнөх улирлын үзүүлэлтээс гүйлгээний дүн ба гүйлгээний тооны хувьд 11.8 ба 18.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт III).




Өөрийн, дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр (бэлэн, бэлэн бус) мянган ширхэг, тэрбум төгрөг

| Хүснэгт<br>III | Бэлэн бус |          |         |       |                   |         |          |          |                    |        |
|----------------|-----------|----------|---------|-------|-------------------|---------|----------|----------|--------------------|--------|
|                | ПОС       |          | МПОС    |       | Цахим<br>худалдаа |         | ATM/CRM  |          | КИОСК<br>(пос-той) |        |
|                | Тоо       | Дүн      | Тоо     | Дүн   | Тоо               | Дүн     | Тоо      | Дүн      | Тоо                | Дүн    |
| 2020-I улирал  | 73,542.65 | 1,777.24 | 39.91   | 0.90  | 327.25            | 27.18   | 3,909.75 | 2,221.41 | 76.39              | 2.20   |
| 2020-II улирал | 89,687.49 | 2,026.10 | 31.18   | 0.91  | 337.42            | 13.33   | 4,188.70 | 2,574.78 | 83.98              | 2.07   |
| Өөрчлөлт       | 16,144.84 | 248.86   | (8.72)  | 0.01  | 10.17             | (13.85) | 278.94   | 353.38   | 7.60               | (0.13) |
| Өөрчлөлт %     | 21.95%    | 14.00%   | -21.86% | 0.62% | 3.11%             | -50.97% | 7.13%    | 15.91%   | 9.95%              | -6.12% |

| Бэлэн  |        |         |         |                 |          |                |          | Нийт       |          |
|--------|--------|---------|---------|-----------------|----------|----------------|----------|------------|----------|
| ПОС    |        | ПОБ     |         | ATM/CRM зарлага |          | CDM/CRM орлого |          |            |          |
| Тоо    | Дүн    | Тоо     | Дүн     | Тоо             | Дүн      | Тоо            | Дүн      | Тоо        | Дүн      |
| 136.89 | 6.58   | 370.61  | 91.18   | 16,679.51       | 2,322.29 | 5,252.02       | 1,786.99 | 100,334.98 | 8,235.98 |
| 158.60 | 7.95   | 331.26  | 79.84   | 17,857.40       | 2,470.76 | 5,798.56       | 2,028.24 | 118,474.59 | 9,203.97 |
| 21.71  | 1.37   | (39.36) | (11.34) | 1,177.89        | 148.47   | 546.54         | 241.24   | 18,139.61  | 968.00   |
| 15.86% | 20.80% | -10.62% | -12.43% | 7.06%           | 6.39%    | 10.41%         | 13.50%   | 18.08%     | 11.75%   |

Төхөөрөмжөөр хийгдсэн нийт гүйлгээг Бэлэн бус, Бэлэн гэж ангилж байгаагаас, ПОС төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний тоо хамгийн их буюу нийт бэлэн бус гүйлгээний 95.1 хувийг эзэлж байгааг Хавсралтад заасан Хүснэгт 3а, 3б, 3в-ийн үзүүлэлтээс харж болно. Гүйлгээний дүнгийн хувьд ATM/CRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн нийт төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 55.8 хувийг эзэлж байна. Бэлнээр хийгдсэн гүйлгээний тоо ба дүнгийн хувьд ATM/CRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ нийт бэлнээр хийгдсэн гүйлгээний тооны 74, дүнгийн 53.9 хувийг эзэлж байна (Хүснэгт 3а, 3б, 3в).

Гүйлгээний тоо ба дүнг төхөөрөмж тус бүрээр авч үзвэл 89.7 сая ширхэг, 2 их наяд төгрөгийн гүйлгээ ПОС ба Киоск төхөөрөмжөөр хийгдсэн нь 2020 оны I улиралд хийгдсэн гүйлгээний тооноос 21.9 хувь, гүйлгээний дүн 14 хувиар өссөн байна. ATM, CDM, CRM төхөөрөмжүүдээр энэ оны II улиралд нийт 27.8 сая ширхэг, 7.1 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх улирлаас тооны хувьд 7.8 хувиар, дүнгийн хувьд 11.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгааг Зураг 6-д үзүүлэв.



Тайлант улиралд ПОВ төхөөрөмжөөр нийт 79.8 тэрбум төгрөгийн 331.3 мянган гүйлгээ хийгдсэн байгаа нь өмнөх улирлын үзүүлэлтээс дүнгийн хувьд 12.4, тооны хувьд 10.6 хувиар тус тус буурсан байна. МПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоог өмнөх улиралтай харьцуулахад 39.9 мянган ширхэгээс 31.2 мянган ширхэг гүйлгээ болж 21.9 хувиар буурсан ч, дүнгийн хувьд 907.6 сая гүйлгээ болж 0.62 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин Цахим худалдааны хувьд нийт 27.2 тэрбум төгрөгийн 327.3 мянган гүйлгээ энэ оны I улиралд хийгдсэн байснаас 13.3 тэрбум төгрөгийн 337.4 мянган гүйлгээ болж тооны хувьд 3.1 хувиар өссөн ч, дүнгийн хувьд 51 хувиар буурсан байна (Хүснэгт 4).

Сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөрийн хэрэгсэлийн хэрэглээ нэмэгдэж байгааг

картын үйлчилгээнд хамгийн өргөнөөр ашиглагдаж буй ПОС (Киоск), АТМ (СDМ, СRМ) төхөөрөмжийн хэрэглээний өөрчлөлтөөр Зураг 7-д үзүүлээ. ПОС төхөөрөмжийн хэрэглээ буюу бэлэн бус төлбөрийн хэмжээ 2016 онд нийт картын гүйлгээний 43.5 хувийг эзэлж байсан бол 2017 оноос 56.1 болж нэмэгдсээр 2018 онд 65.3 хувь, 2020 оны II улирлын байдлаар 75.9 хувьд хүрчээ. Харин АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо буюу бэлэн бус мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх хэрэглээ 2016 онд картын нийт гүйлгээний 55.6 хувийг эзэлж байсан бол 2017 оноос буурсаар 2018 онд 33.2 хувь, 2020 оны II улирлын байдлаар 23.5 хувь болсон байна. Энэ нь иргэд төлбөр тооцоогоо бэлэн бусаар хийх хандлага өссөөр байгааг харуулж байна (Хүснэгт 4).

ПОС (Киоск пос-той) төхөөрөмжийн хэрэглээ дүнгийн хувьд 2016 онд нийт картын гүйлгээний дүнгийн 15.4 хувийг эзэлж байсан бол 2020 оны II улирлын байдлаар 22.1 хувьд хүрчээ. Харин АТМ (СДМ, СРМ) төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 2016 онд нийт картын гүйлгээний 83 хувийг эзэлж байсан бол 2020 оны II улирлын байдлаар 76.9 хувь болсон байгааг Зураг 8-д үзүүлээ.





ҮЦГТ-ын нэгдсэн сүлжээнд 2020 оны II улиралд хийгдсэн гүйлгээний тоо ба дүнг Худалдаа үйлчилгээний төрлөөр ангилсны хураангуйг Хүснэгт IV-өөс харж болно. Хүснэгтээс үзэхэд хүнсний дэлгүүр, супермаркет, хоолны газар болон АТМ-д хамгийн их буюу хэрэглэгчдийн дийлэнх гүйлгээ төвлөрдөг бол харилцаа холбооны төлбөр, цахилгаан барааны төлбөр, шатахууны төлбөр болон шөнийн цэнгээний газарт хийгдсэн гүйлгээ хамгийн бага хувийг эзэлж байна.


| Хүснэгт IV. ҮЦГТ-өөр дамжсан картын гүйлгээний тоо ба дүн худалдаа үйлчилгээнтэй төрлөөр (2020-II) |            |                   |                                                 |            |                |
|----------------------------------------------------------------------------------------------------|------------|-------------------|-------------------------------------------------|------------|----------------|
| Нэр төрөл (ТОП 15)                                                                                 | КУБ дугаар | Мөнгөн дүн        | Нэр төрөл (ТОП 15)                              | КУБ дугаар | Гүйлгээний тоо |
| 1.Хүнсний дэлгүүр, супермаркет                                                                     | 5411       | 387,645,607,309   | 1.Хүнсний дэлгүүр, супермаркет                  | 5411       | 27,898,516     |
| 2.АТМ-ын гүйлгээ                                                                                   | 6011       | 350,505,396,000   | 2.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/             | 5499       | 6,666,493      |
| 3.Төрөл бүрийн хүнсний цэгүүд /ТҮЦ/                                                                | 5499       | 82,590,335,441    | 3.АТМ-ын гүйлгээ                                | 6011       | 4,381,036      |
| 4.Хоолны газар, ресторан                                                                           | 5812       | 64,373,500,543    | 4.Хоолны газар, ресторан                        | 5812       | 3,172,043      |
| 5.ПОБ-ын гүйлгээ                                                                                   | 6010       | 56,403,053,747    | 5.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр | 5912       | 2,670,111      |
| 6.Шатахуун түгээх газар                                                                            | 5542       | 54,035,570,403    | 6.Шатахуун түгээх газар                         | 5542       | 1,343,677      |
| 7.Эм, гоо сайхан, ариун цэврийн барааны дэлгүүр                                                    | 5912       | 50,456,612,548    | 7.Их дэлгүүр                                    | 5311       | 1,014,508      |
| 8.Их дэлгүүр                                                                                       | 5311       | 40,055,075,879    | 8.Түргэн хоолны газар                           | 5814       | 994,506        |
| 9.Гэр бүлийн хувцасны дэлгүүр                                                                      | 5651       | 33,274,659,223    | 9.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр      | 5691       | 742,361        |
| 10.Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцасны дэлгүүр                                                        | 5691       | 33,087,520,002    | 10.Төрөлжсөн бус барааны дэлгүүр                | 5331       | 710,423        |
| 11.Эмнэлэг                                                                                         | 8062       | 24,708,509,246    | 11.Гэр бүлийн хувцасны дэлгүүр                  | 5651       | 675,510        |
| 12.Автомашин үйлчилгээний цэгүүд                                                                   | 5541       | 21,221,305,525    | 12.Автомашин үйлчилгээний цэгүүд                | 5541       | 606,804        |
| 13.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/                                                    | 5983       | 21,017,580,093    | 13.Шатахууны жижиглэн худалдаа /non-automotive/ | 5983       | 594,555        |
| 14.Цахилгаан хэрэгслийн дэлгүүр                                                                    | 5732       | 18,252,371,346    | 14.Шөнийн цэнгээний газар, паб                  | 5813       | 540,815        |
| 15.Харилцаа холбооны үйлчилгээ                                                                     | 4814       | 17,943,246,095    | 15.Харилцаа холбооны үйлчилгээ                  | 4814       | 427,201        |
| 16.Бусад                                                                                           |            | 407,336,265,373   | 16.Бусад                                        |            | 9,393,816      |
| Нийт                                                                                               |            | 1,662,906,608,774 | Нийт                                            |            | 61,832,375     |

Хүснэгт IV -ийн үзүүлэлтийг хувьчилж Зураг 9 ба 10-д үзүүлэв.

Зураг 9. 2020 оны II улиралын картын гүйлгээний дүн /төрлөөр/



Зураг 10. 2020 оны II улиралын картын гүйлгээний тоо /төрлөөр/



- **Залилангийн гүйлгээ.**

Залилангийн гүйлгээний хувьд өмнөх оны II улиралтай харьцуулахад гүйлгээний тоо 7.1 хувиар, дүн нь 37.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт ба,б,в). Харин тайлант хугацаанд нийт 182 удаагийн үйлдлээр 31.9 сая төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх I улиралтай харьцуулахад тооны хувьд 21.9 хувиар, дүнгийн хувьд 81.8 хувиар тус тус буурсан. Үүнд:

- **Картын төрлөөр:**

1. ₮ карт 29 удаагийн үйлдлээр 5.8 сая төгрөг;
2. Виза карт 137 удаагийн үйлдлээр 22.1 сая төгрөг;
3. Мастеркарт 9 удаагийн үйлдлээр 961 мянган сая төгрөг;
4. ЮнионПэй 3 удаагийн үйлдлээр 2.9 сая төгрөг;
5. Американ экспресс 4 удаагийн үйлдлээр 145.6 мянган сая төгрөг.

- **Төхөөрөмжийн төрлөөр:**

1. ПОС 20 удаагийн үйлдлээр 3.2 сая төгрөг;
2. МПОС 3 удаагийн үйлдлээр 2.8 сая төгрөг
3. АТМ/СRM 29 удаагийн үйлдлээр 16 сая төгрөг;
4. Цахим худалдаа 130 удаагийн үйлдлээр 9.9 сая төгрөгийн залилангийн гүйлгээ тус тус хийгдсэн байна (Хүснэгт ба,б,в).

## **2. ТӨЛБӨРИЙН БУСАД**

### **ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ**

Тайлант хугацаанд төлбөрийн бусад хэрэгслээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг ангилж үзэхэд дараах үзүүлэлттэй байна. Банкуудын илгээсэн гүйлгээг төлбөрийн хэрэгслээр тодруулбал:

- Бэлэн мөнгө – 5.8 их наяд төгрөгийн 3.6 сая ширхэг;
- Кредит шилжүүлэг – 39.7 их наяд төгрөгийн 19.6 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 115.1 тэрбум төгрөгийн 10.4 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 10.5 их наяд төгрөгийн 50 мянган ширхэг (Хүснэгт 5).

Харин банкуудын хүлээн авсан гүйлгээг төлбөрийн хэрэгслээр задалбал:

- Бэлэн мөнгө – 5.6 их наяд төгрөгийн 4.3 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 59 тэрбум төгрөгийн 39.2 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 5.1 их наяд төгрөгийн 44.4 мянган ширхэг (Хүснэгт 5).

Дээрх үзүүлэлтээс үзэхэд банкн дээр хийгдэж буй харилцагчийн гүйлгээнээс шилжүүлгийн төрөл өмнөх оны үзүүлэлтийн адилаар хамгийн их буюу 73.2 хувийг эзэлж байгаа бол мөнгөн гуйвуулга дүнгийн хувьд хамгийн бага буюу нийт гүйлгээний дүнгийн 0.3 хувийг эзэлж байна.

**3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ**

Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээний тооны дийлэнх хувийг бага дүнтэй гүйлгээ, дүнгийн ихэнх хувийг их дүнтэй гүйлгээ тус тус эзэлдэг харьцаа тайлант улиралд хэвээр хадгалагджээ. 2020 оны II улирлын байдлаар нийт гүйлгээний тооны 70.4 хувь буюу 15.5 сая ширхэгийг бодит цагийн гүйлгээ буюу бага дүнтэй гүйлгээ (RTP), 27.8 хувь буюу 6.1 сая ширхэгийг багцын гүйлгээ (ACH), үлдсэн 1.8 хувийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна (RTGS). Харин нийт гүйлгээний дүнгийн 94.9 хувь буюу 80.2 их наяд төгрөгийг их дүнтэй гүйлгээ эзэлж байна (Хүснэгт 7).

Бодит цагийн гүйлгээний тоог өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 1 сая ширхэг буюу 7.1 хувиар, их дүнтэй гүйлгээний тоо 21.2 мянган ширхэг буюу 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Их дүнтэй гүйлгээний дүнг өмнөх оны II улиралтай харьцуулахад 5.1 их наяд буюу 6.7 хувиар, бодит цагийн гүйлгээний дүн 550.4 тэрбум буюу 22 хувиар өссөн байна. Бодит цагийн гүйлгээний дүнгийн дээд хязгаарыг нэмэгдүүлж, 3 хүртэл сая төгрөгийн дүнтэй гүйлгээг бага дүнтэй буюу бодит цагийн гүйлгээний (RTP) системээр дамжуулах болсон нь гүйлгээний дүнгийн өөрчлөлтөнд нөлөөлсөн (Хүснэгт 7).

I. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ  
Хүснэгт 1а. Картын хэрэглээний тайлан

(Өссөн дүнгээр)

|                                    | 2019 он,<br>II улирал | 2020 он,<br>I улирал | 2020 он,<br>II улирал | Өсөлт/бууралт (2019-II-2020-II) |       |
|------------------------------------|-----------------------|----------------------|-----------------------|---------------------------------|-------|
|                                    |                       |                      |                       | Тоо                             | хувь  |
| Картын тоо                         | 3,652,670             | 3,747,867            | 3,862,914             | 210,244                         | 5.76  |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо | 1,506,404             | 1,654,038            | 1,808,048             | 301,644                         | 20.02 |

|                                    |               | 2019 он,<br>II улирал | 2020 он,<br>II улирал | Өсөлт/бууралт |       |
|------------------------------------|---------------|-----------------------|-----------------------|---------------|-------|
|                                    |               |                       |                       | Тоо           | Хувь  |
| Картын тоо                         | Хотууд        | 2,554,280             | 2,589,431             | 35,151        | 1.38  |
|                                    | Бусад аймгууд | 1,110,613             | 1,273,483             | 162,870       | 14.66 |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо |               | 1,506,404             | 1,808,048             | 301,644       | 20.02 |

Хүснэгт 1б. Картын хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/04/2020 - 30/06/2020

| №                   | Хот,<br>аймаг | ₮ карт     |           | Виза      |           |                       |        | Мастеркарт |        |                       |        | ЮнионПэй   |          |                       |          | Амекс  |        |                       |        | ЖейСиБи  |        |                       |        | Нийт<br>картын<br>тоо |
|---------------------|---------------|------------|-----------|-----------|-----------|-----------------------|--------|------------|--------|-----------------------|--------|------------|----------|-----------------------|----------|--------|--------|-----------------------|--------|----------|--------|-----------------------|--------|-----------------------|
|                     |               | Энгийн     |           | Энгийн    |           | ₮ карттай<br>хосолсон |        | Энгийн     |        | ₮ карттай<br>хосолсон |        | Энгийн     |          | ₮ карттай<br>хосолсон |          | Энгийн |        | ₮ карттай<br>хосолсон |        | Энгийн   |        | ₮ карттай<br>хосолсон |        |                       |
|                     |               | Дебит      | Кредит    | Дебит     | Кредит    | Дебит                 | Кредит | Дебит      | Кредит | Дебит                 | Кредит | Дебит      | Кредит   | Дебит                 | Кредит   | Дебит  | Кредит | Дебит                 | Кредит | Дебит    | Кредит | Дебит                 | Кредит |                       |
| 1                   | Улаанбаатар   | 1,415,393  | 26,764    | 290,075   | 65,795    | 0                     | 0      | 73,020     | 2,927  | 12,767                | 0      | 154,723    | 8,180    | 228,973               | 51,571   | 509    | 2,521  | 0                     | 0      | 4,629    | 0      | 0                     | 0      | 2,337,847             |
| 2                   | Дархан-Уул    | 86,102     | 1,504     | 7,003     | 2,456     | 0                     | 309    | 280        | 61     | 153                   | 0      | 14,499     | 184      | 9,065                 | 2,989    | 214    | 8      | 0                     | 0      | 262      | 0      | 0                     | 0      | 125,089               |
| 3                   | Орхон         | 85,659     | 1,189     | 9,169     | 2,861     | 0                     | 0      | 337        | 105    | 212                   | 0      | 14,821     | 327      | 9,214                 | 2,086    | 118    | 31     | 0                     | 0      | 366      | 0      | 0                     | 0      | 126,495               |
| Нийт (дээрх хотууд) |               | 1,587,154  | 29,457    | 306,247   | 71,112    | 0                     | 309    | 73,637     | 3,093  | 13,132                | 0      | 184,043    | 8,691    | 247,252               | 56,646   | 841    | 2,560  | 0                     | 0      | 5,257    | 0      | 0                     | 0      | 2,589,431             |
| Нийт эзлэх %        |               | 63.88%     |           | 84.61%    |           |                       |        | 95.57%     |        |                       |        | 63.75%     |          |                       |          | 93.15% |        |                       |        | 57.36%   |        |                       |        | 67.03%                |
| 4                   | Бусад аймгууд | 894,263.00 | 19,738.00 | 51,229.00 | 17,469.00 | 0.00                  | 0.00   | 2,626.00   | 501.00 | 1,043.00              | 0.00   | 183,204.00 | 2,660.00 | 93,481.00             | 3,111.00 | 181.00 | 69.00  | 0.00                  | 0.00   | 3,908.00 | 0.00   | 0.00                  | 0.00   | 1,273,483             |
| Нийт эзлэх %        |               | 36.12%     |           | 15.39%    |           |                       |        | 4.43%      |        |                       |        | 36.25%     |          |                       |          | 6.85%  |        |                       |        | 42.64%   |        |                       |        | 32.97%                |
| Нийт (Улс)          |               | 2,481,417  | 49,195    | 357,476   | 88,581    | 0                     | 309    | 76,263     | 3,594  | 14,175                | 0      | 367,247    | 11,351   | 340,733               | 59,757   | 1,022  | 2,629  | 0                     | 0      | 9,165    | 0      | 0                     | 0      | 3,862,914             |
| Нийт (Улс)          |               | 2,530,612  |           | 446,366   |           |                       |        | 94,032     |        |                       |        | 779,088    |          |                       |          | 3,651  |        |                       |        | 9,165    |        |                       |        | 3,862,914             |



Хүснэгт 1в. Карт эзэмшигч - Нэр төрлөөр

2017 - 2020 он (картын тоо өссөн дүнгээр)

| Он                        | ₮ карт    | Виза    | Мастеркарт | ЮнионПэй | Амекс   | ЖейСиБи | Нийт      |
|---------------------------|-----------|---------|------------|----------|---------|---------|-----------|
| 2017 он, II улирал        | 2,729,858 | 715,625 | 24,491     | 381,701  | 14,255  | 134     | 3,866,064 |
| 2018 он, II улирал        | 2,930,592 | 633,933 | 10,178     | 425,777  | 6,759   | 612     | 4,007,851 |
| 2019 он, II улирал        | 2,736,627 | 350,500 | 45,732     | 503,788  | 5,880   | 10,143  | 3,652,670 |
| 2020 он, II улирал        | 2,530,612 | 446,366 | 94,032     | 779,088  | 3,651   | 9,165   | 3,862,914 |
| Өсөлт/бууралт (2020-II)   | -7.53     | 27.35%  | 105.62%    | 54.65%   | -37.91% | -9.64%  | 5.76%     |
| Нийт зах зээлд эзлэх хувь | 65.51%    | 11.56%  | 2.43%      | 20.17%   | 0.09%   | 0.24%   | 100.00%   |

Хүснэгт 2а. Төхөөрөмжийн хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/04/2020 - 30/06/2020

| №             | Хот, аймаг  | ПОС    | МПОС   | ПОБ    | АТМ    | CDM    | CRM    | Цахим худалдаа | "КИОСК (пос-той)" | Бусад   | Нийт   |
|---------------|-------------|--------|--------|--------|--------|--------|--------|----------------|-------------------|---------|--------|
| 1             | Улаанбаатар | 46,287 | 1,882  | 1,423  | 701    | 34     | 1,120  | 679            | 132               | 9       | 52,267 |
| 2             | Дархан-Уул  | 1,720  | 136    | 71     | 49     | 4      | 38     | 2              | 3                 | 0       | 2,023  |
| 3             | Орхон       | 1,496  | 3      | 65     | 46     | 1      | 36     | 0              | 8                 | 0       | 1,655  |
| Нийт (Хотууд) |             | 49,503 | 2,021  | 1,559  | 796    | 39     | 1,194  | 681            | 143               | 9       | 55,945 |
| Нийт эзлэх %  |             | 76.84% | 94.97% | 56.81% | 71.58% | 88.64% | 77.58% | 98.84%         | 85.63%            | 100.00% | 76.79% |
| 4             | Бусад аймаг | 14,919 | 107    | 1,185  | 316    | 5      | 345    | 8              | 24                | 0       | 16,909 |
| Нийт эзлэх %  |             | 23.16% | 5.03%  | 43.19% | 28.42% | 11.36% | 22.42% | 1.16%          | 14.37%            | 0.00%   | 23.21% |
| Нийт (Улс)    |             | 64,422 | 2,128  | 2,744  | 1,112  | 44     | 1,539  | 689            | 167               | 9       | 72,854 |

Хүснэгт 2б. Төхөөрөмжийн тоо

2019 - 2020 он (төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр)

| №    | Төхөөрөмж         | 2019 он, II улирал | 2020 он, I улирал | 2020 он, II улирал | Өсөлт/бууралт |         | Нийт төхөөрөмжид эзлэх хувь |
|------|-------------------|--------------------|-------------------|--------------------|---------------|---------|-----------------------------|
|      |                   |                    |                   |                    | Тоогоор       | Хувиар  |                             |
| 1    | ПОС               | 50,837             | 62,461            | 64,422             | 1,961         | 3.14    | 88.42                       |
| 2    | МПОС              | 3,005              | 2,936             | 2,128              | (808)         | (27.52) | 2.92                        |
| 3    | ПОБ               | 1,895              | 2,468             | 2,744              | 276           | 11.18   | 3.77                        |
| 4    | АТМ               | 2,412              | 1,266             | 1,112              | (154)         | (12.16) | 1.53                        |
| 5    | CDM* <sup>5</sup> | 0                  | 46                | 44                 | (2)           | (4.35)  | 0.06                        |
| 6    | CRM*              | 0                  | 1,484             | 1,539              | 55            | 3.71    | 2.11                        |
| 7    | Цахим худалдаа*   | 0                  | 779               | 689                | (90)          | 11.55   | 0.95                        |
| 8    | Киоск*            | 0                  | 168               | 167                | 1             | (0.60)  | 0.23                        |
| 9    | Бусад             | 332                | 0                 | 9                  | 9             | 900     | 0.01                        |
| Нийт |                   | 50,333             | 69,005            | 72,854             | 3,849         | 5.58    | 100                         |

\*Төхөөрөмжийн хэрэглээний тайланд 2019 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн төхөөрөмжийн тоог 9 нэр төрлөөр бүртгэж эхэлсэн болно

Хүснэгт 3а. Өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Картын төрлөөр

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

|      | ₮ карт    |          | Виза     |          | Мастеркарт |       | ЮнионПэй  |          | Амекс |      | ЖейСиБи |      | Нийт      |          |
|------|-----------|----------|----------|----------|------------|-------|-----------|----------|-------|------|---------|------|-----------|----------|
|      | Тоо       | Дүн      | Тоо      | Дүн      | Тоо        | Дүн   | Тоо       | Дүн      | Тоо   | Дүн  | Тоо     | Дүн  | Тоо       | Дүн      |
| Нийт | 42,262.82 | 4,397.24 | 6,612.04 | 1,484.23 | 302.72     | 24.41 | 14,471.20 | 1,727.84 | 34.42 | 7.48 | 19.77   | 1.63 | 63,702.97 | 7,642.82 |

Хүснэгт 3б. Өөрийн гаргасан картаар нэгдсэн, гадаад сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| №    | Хүлээн авагч<br>төхөөрөмж | Нэгдсэн сүлжээ |        |          |        |            |       |           |        |       |      |         |      | Гадаад сүлжээ |        |            |       |          |      |       |      |         |      | Нийт      |          |
|------|---------------------------|----------------|--------|----------|--------|------------|-------|-----------|--------|-------|------|---------|------|---------------|--------|------------|-------|----------|------|-------|------|---------|------|-----------|----------|
|      |                           | ₮ карт         |        | Виза     |        | Мастеркарт |       | ЮнионПэй  |        | Амекс |      | ЖейСиБи |      | Виза          |        | Мастеркарт |       | ЮнионПэй |      | Амекс |      | ЖейСиБи |      |           |          |
|      |                           | Тоо            | Дүн    | Тоо      | Дүн    | Тоо        | Дүн   | Тоо       | Дүн    | Тоо   | Дүн  | Тоо     | Дүн  | Тоо           | Дүн    | Тоо        | Дүн   | Тоо      | Дүн  | Тоо   | Дүн  | Тоо     | Дүн  | Тоо       | Дүн      |
| 1    | ПОС                       | 36,612.87      | 701.30 | 7,928.20 | 271.87 | 542.49     | 21.98 | 12,485.90 | 268.05 | 0.00  | 0.00 | 60.72   | 1.18 | 239.07        | 35.48  | 6.76       | 1.81  | 9.61     | 2.12 | 5.93  | 2.80 | 0.35    | 0.05 | 57,891.90 | 1,306.62 |
| 2    | ПОБ                       | 156.84         | 33.05  | 43.99    | 15.00  | 0.67       | 0.16  | 36.56     | 8.58   | 0.00  | 0.00 | 0.06    | 0.01 | 5.17          | 1.50   | 0.00       | 0.01  | 0.02     | 0.14 | 0.00  | 0.00 | 0.00    | 0.00 | 243.30    | 58.45    |
| 3    | АТМ                       | 2,253.82       | 236.79 | 359.20   | 43.46  | 30.14      | 3.83  | 717.79    | 69.43  | 0.00  | 0.00 | 6.27    | 0.71 | 28.24         | 20.25  | 1.47       | 0.64  | 7.35     | 4.21 | 0.08  | 0.08 | 0.06    | 0.04 | 3,404.42  | 379.44   |
| 4    | Цахим худалдаа            | 17.13          | 0.64   | 8.89     | 0.62   | 0.55       | 0.04  | 8.41      | 0.44   | 0.00  | 0.00 | 3.01    | 0.39 | 420.57        | 72.60  | 75.51      | 8.52  | 0.57     | 0.13 | 4.08  | 1.34 | 0.13    | 0.01 | 538.86    | 84.71    |
| Нийт |                           | 39,040.66      | 971.77 | 8,340.28 | 330.94 | 573.85     | 26.00 | 13,248.66 | 346.51 | 0.00  | 0.00 | 70.06   | 2.28 | 693.05        | 129.83 | 83.74      | 10.98 | 17.55    | 6.60 | 10.09 | 4.22 | 0.54    | 0.09 | 62,078.48 | 1,829.22 |

Хүснэгт 3в. Гүйлгээний тоо, дүн – Карт гаргагч, хүлээн авагчаар

2018 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| Он                             | Утга | Карт гаргагч  |                |               | Карт хүлээн авагч |                          |
|--------------------------------|------|---------------|----------------|---------------|-------------------|--------------------------|
|                                |      | Дотоод сүлжээ | Нэгдсэн сүлжээ | Гадаад сүлжээ | Бусад банкны карт | Гадаад байгууллагын карт |
| 2018 он, II улирал             | Тоо  | 47,345.38     | 35,742.98      | 613.40        | 35,997.59         | 367.95                   |
|                                | Дүн  | 8,505.89      | 1,260.57       | 170.32        | 1,238.24          | 86.90                    |
| 2019 он, II улирал             | Тоо  | 58,875.14     | 51,924.46      | 788.84        | 50,437.63         | 447.68                   |
|                                | Дүн  | 9,102.97      | 1,603.43       | 202.30        | 1,542.24          | 100.60                   |
| 2020 он, II улирал             | Тоо  | 63,702.97     | 61,273.51      | 804.97        | 54,641.32         | 130.89                   |
|                                | Дүн  | 7,642.82      | 1,677.50       | 151.72        | 1,535.39          | 25.88                    |
| Өсөлт/бууралт хувиар (2020-II) | Тоо  | 8.20          | 18.01          | 2.04          | 8.33              | (70.36)                  |
|                                | Дүн  | (16.04)       | 4.62           | (25.00)       | (0.44)            | (74.27)                  |

Хүснэгт 4. Төхөөрөмж тус бүрээр хийсэн гүйлгээний дүн, тоо

2019 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| №          | Төхөөрөмж      | Утга | 2019 он, II улирал | 2020 он, I улирал | 2020 он, II улирал | Өсөлт/бууралт<br>(хувиар) |
|------------|----------------|------|--------------------|-------------------|--------------------|---------------------------|
| 1          | ПОС            | Тоо  | 75,670.11          | 73,679.54         | 89,846.09          | 21.94%                    |
|            |                | Дүн  | 1,843.67           | 1,783.82          | 2,034.05           | 14.03%                    |
| 2          | МПОС           | Тоо  | 152.97             | 39.91             | 31.18              | -21.86%                   |
|            |                | Дүн  | 2.02               | 0.9               | 0.91               | 0.85%                     |
| 3          | ПОБ            | Тоо  | 463.84             | 370.61            | 331.26             | -10.62%                   |
|            |                | Дүн  | 130.38             | 91.18             | 79.84              | -12.44%                   |
| 4          | АТМ/CRM/CDM    | Тоо  | 34,815.69          | 25,841.29         | 27,844.65          | 7.75%                     |
|            |                | Дүн  | 8,893.28           | 6,330.69          | 7,073.78           | 11.74%                    |
| 5          | Цахим худалдаа | Тоо  | 0                  | 327.25            | 337.42             | 3.11%                     |
|            |                | Дүн  | 0                  | 27.18             | 13.33              | -50.97%                   |
| 6          | Киоск          | Тоо  | 0                  | 76.39             | 83.98              | 9.94%                     |
|            |                | Дүн  | 0                  | 2.2               | 2.07               | -6.10%                    |
| 7          | Бусад          | Тоо  | 0                  | 0                 | 0                  | 0.00%                     |
|            |                | Дүн  | 0                  | 0                 | 0                  | 0.00%                     |
| Нийт (Улс) |                | Тоо  | 111,102.61         | 100,334.99        | 118,474.59         | 18.08%                    |
|            |                | Дүн  | 10,869.35          | 8,235.97          | 9,203.97           | 11.75%                    |

Хүснэгт 5. Төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тайлан - Илгээсэн гүйлгээ

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| Гүйлгээний төрөл     | Бэлэн мөнгө |          | Кредит шилжүүлэг |           | Гуйвуулга     |       |           |       |                        |       | Гадаад шилжүүлэг<br>(SWIFT) |           | Нийт      |           |
|----------------------|-------------|----------|------------------|-----------|---------------|-------|-----------|-------|------------------------|-------|-----------------------------|-----------|-----------|-----------|
|                      |             |          |                  |           | Western Union |       | Moneygram |       | Бусад мөнгөн гуйвуулга |       |                             |           |           |           |
|                      | Тоо         | Дүн      | Тоо              |           | Тоо           | Дүн   | Тоо       | Дүн   | Тоо                    | Дүн   | Тоо                         | Дүн       | Тоо       | Дүн       |
| Илгээсэн гүйлгээ     | 3,623.24    | 5,838.33 | 19,632.36        | 39,744.71 | 0.95          | 94.88 | 1.76      | 3.69  | 7.64                   | 16.52 | 50.02                       | 10,484.35 | 23,315.97 | 56,182.49 |
| Хүлээн авсан гүйлгээ | 4,306.35    | 5,565.08 | 0.00             | 0.00      | 6.05          | 11.04 | 20.09     | 29.00 | 13.07                  | 18.96 | 44.35                       | 5,112.60  | 4,389.91  | 10,736.67 |

Хүснэгт ба. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Картын төрлөөр

01/04/2020 - 30/06/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| № |     | Өөрийн гаргасан карт |      |            |          |       |         | Дотоодын бусад банкны гаргасан карт |      |            |          |       |         | Гадаадын байгууллагын гаргасан карт |            |          |       |         | Нийт  |
|---|-----|----------------------|------|------------|----------|-------|---------|-------------------------------------|------|------------|----------|-------|---------|-------------------------------------|------------|----------|-------|---------|-------|
|   |     | ₮ карт               | Виза | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи | ₮ карт                              | Виза | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи | Виза                                | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи |       |
| 1 | Тоо | 0.03                 | 0.13 | 0.01       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00 | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.182 |
| 2 | Дүн | 0.01                 | 0.02 | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00 | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.032 |

Хүснэгт бб. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

01/04/2020 - 30/06/2020

| №    | Байршил    | Төхөөрөмж      | Тоо | Дүн           |
|------|------------|----------------|-----|---------------|
| 1    | Монгол улс | ПОС            | 16  | 2,819,519.00  |
| 2    |            | МПОС           | 3   | 2,830,500.00  |
| 3    |            | АТМ/СRМ        | 27  | 8,604,488.53  |
| 4    |            | Цахим худалдаа | 2   | 225,061.20    |
| 5    | Олон улс   | ПОС            | 4   | 336,370.00    |
| 6    |            | АТМ/СRМ        | 2   | 7,400,000.00  |
| 7    |            | Цахим худалдаа | 128 | 9,701,699.64  |
| Нийт |            |                | 182 | 31,917,638.37 |

Хүснэгт бв. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

2018 - 2020 он (сая төгрөгөөр)

| Он                     | Утга | ПОС     | АТМ/СRМ | Цахим худалдаа | Бусад   | Нийт    |
|------------------------|------|---------|---------|----------------|---------|---------|
| 2018 он, II улирал     | Тоо  | 18      | 131     | 13             | 1       | 163     |
|                        | Дүн  | 3.57    | 16.48   | 4.28           | 0.3     | 24.63   |
| 2019 он, II улирал     | Тоо  | 25      | 107     | 19             | 19      | 140     |
|                        | Дүн  | 4.85    | 11.38   | 0.002          | 6.97    | 46.9    |
| 2020 он, II улирал     | Тоо  | 20      | 29      | 130            | 3       | 182     |
|                        | Дүн  | 3.16    | 16.00   | 9.93           | 2.83    | 32      |
| Өсөлт/бууралт (хувиар) | Тоо  | -20.00% | -72.90% | 584.21%        | -84.21% | 30.00%  |
|                        | Дүн  | -34.93% | 40.64%  | 496238.04%     | -59.39% | -31.95% |

## ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Хүснэгт 7. Их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн

2018-2020 он (мянган ширхэг, их наяд төгрөг)

|                                   | 2018 он   |       |       |      | 2019 он <sup>6</sup> |        |       |       | 2020 он   |       |       |       |
|-----------------------------------|-----------|-------|-------|------|----------------------|--------|-------|-------|-----------|-------|-------|-------|
|                                   | тоо       | %     | дүн   | %    | тоо                  | %      | дүн   | %     | тоо       | %     | дүн   | %     |
| I улирал                          | 9,295.8   | 32.2  | 20.0  | 46.5 | 13,021.6             | 40     | 69.1  | 245.5 | 12,920.10 | -0.78 | 67.20 | -2.74 |
| Бодит цагийн гүйлгээ (RTP)        | 8,808.8   | 32.3  | 1.2   | 44.0 | 12,727.4             | 44.5   | 2.5   | 108   | 12,599.90 | -1.00 | 3.05  | 22.02 |
| Багцын гүйлгээ (ACH)              | -         |       | -     |      | -                    |        | -     |       | -         |       | -     |       |
| Их дүнтэй гүйлгээ (RTGS)          | 487.0     | 29.2  | 18.8  | 46.8 | 294.2                | -39.58 | 66.6  | 254.2 | 320.20    | 8.84  | 64.15 | -3.67 |
| II улирал                         | 10,992.3  | 45.9  | 22.8  | 15.2 | 14,856.3             | 35.2   | 78.2  | 242.8 | 22,014.99 | 48.19 | 84.45 | 8.06  |
| Бодит цагийн гүйлгээ (RTP)        | 10,379.7  | 47.0  | 1.4   | 48.4 | 14,474.4             | 39.4   | 3.05  | 117.9 | 15,498.30 | 7.07  | 3.65  | 19.67 |
| Багцын гүйлгээ (ACH) <sup>7</sup> | -         |       | -     |      | -                    |        | -     |       | 6,113.57  | -     | 0.64  | -     |
| Их дүнтэй гүйлгээ (RTGS)          | 612.6     | 29.8  | 21.4  | 13.0 | 381.9                | -37.7  | 75.1  | 250.9 | 403.12    | 5.56  | 80.16 | 6.74  |
| III улирал                        | 10,850.6  | 117.0 | 19.7  | 13.6 | 15,114               | 39.3   | 74.1  | 276.1 |           |       |       |       |
| Бодит цагийн гүйлгээ (RTP)        | 10,232.2  | 126.3 | 1.4   | 65.5 | 14,727.2             | 43.9   | 3.2   | 128.6 |           |       |       |       |
| Багцын гүйлгээ (ACH)              | -         |       | -     |      | -                    |        | -     |       |           |       |       |       |
| Их дүнтэй гүйлгээ (RTGS)          | 618.4     | 29.4  | 18.2  | 11.1 | 386.8                | -37.5  | 70.9  | 289.6 |           |       |       |       |
| IV улирал                         | 12,898.7  | 98.0  | 27.7  | 38.5 | 17,532.4             | 35.9   | 87.6  | 216.3 |           |       |       |       |
| Бодит цагийн гүйлгээ (RTP)        | 12,311.6  | 107.3 | 2.1   | 90.9 | 17,099.4             | 38.9   | 3.7   | 76.1  |           |       |       |       |
| Багцын гүйлгээ (ACH)              | -         |       | -     |      | -                    |        | -     |       |           |       |       |       |
| Их дүнтэй гүйлгээ (RTGS)          | 587.1     | 1.9   | 25.6  | 34.7 | 433.0                | -26.3  | 83.9  | 227.8 |           |       |       |       |
| Нийт                              | 44,037.40 | 68.8  | 90.16 | 27.3 | 60,524.3             | 37.4   | 309.0 | 242.7 |           |       |       |       |
| Бодит цагийн гүйлгээ (RTP)        | 41,732.27 |       | 6.08  |      | 59,028.4             |        | 12.4  |       |           |       |       |       |
| эзлэх хувь                        | 95.0      |       | 7.0   |      | 97.5                 |        | 4.0   |       |           |       |       |       |
| Багцын гүйлгээ (ACH)              | -         |       | -     |      | -                    |        | -     |       |           |       |       |       |
| эзлэх хувь                        |           |       |       |      |                      |        |       |       |           |       |       |       |
| Их дүнтэй гүйлгээ (RTGS)          | 2,305.13  |       | 84.03 |      | 1,495.9              |        | 296.5 |       |           |       |       |       |
| эзлэх хувь                        | 5.0       |       | 93.0  |      | 2.5                  |        | 96.0  |       |           |       |       |       |

<sup>6</sup> Өмнөх тайлангуудад их дүнтэй гүйлгээний тоон мэдээг оруулахдаа зөвхөн арилжааны банкуудын дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулдаг байсан бөгөөд 2019 оны I улирлаас эхлэн Монголбанкны өөрийн дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулах болсонтой холбоотойгоор дүнгийн хувьд огцом өссөн үзүүлэлттэй байна.

<sup>7</sup> Багцын гүйлгээ нь нэгж гүйлгээний дүнгийн хязгаарлалт байхгүй тул Бага дүнтэй гүйлгээн дээр бүртгэдэг байсныг 2020 оны II улирлаас эхлэн өөрчилж, ашиглагдаж буй систем тус бүрээр нь ялгаж бүртгэдэг болсон.